



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН
ЛАБОРАТОРИ УТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261740 Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК
Захирал: Б.Жаргалсайхан
Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.Төлбөрийн акт	19
4.3Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
ЗГ	Засгийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/428
танай _____-ны № _____-т

МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ,
БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН
ЛАБОРАТОРИ УТҮГ-ЫН
ЗАХИРАЛ А.ОРГИЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 35,634.0 мянган төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, "Тохиолдсон байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	288,191,824.40	314,392,194.86
33	АВЛАГА	48,342,691.97	22,822,778.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	102,740.19	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	44,133,552.00	21,519,578.00
335	Бусад авлага	4,106,399.78	1,303,200.00
3351	Байгууллагаас авах авлага	4,106,399.78	1,303,200.00
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	239,849,132.43	284,369,416.86
351	Түүхий эд материал	102,098,505.49	108,246,043.33
35110	Тусгай зориулалттай материал	100,147,335.49	106,616,193.33
35130	Эм боох материал	1,951,170.00	1,629,850.00
354	Хангамжийн материал	109,166,051.94	131,079,473.53
35410	Бичиг хэргийн материал	4,140,386.00	7,339,846.00
35420	Аж ахуйн материал	80,489,804.83	93,310,769.56
35430	Сэлбэг хэрэгсэл	184,600.00	559,750.00
35440	Түлш, шатах тослох материал	3,539,000.00	2,210,000.00
35470	Бусад хангамжийн материал	20,812,261.11	27,659,107.97
35600	Мал амьтад	28,584,575.00	45,043,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	926,374,950.04	798,867,343.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	926,374,950.04	798,867,343.18
392	Биет хөрөнгө	897,157,327.78	771,638,054.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	560,261,802.00	560,261,802.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(67,219,189.83)	(104,365,801.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,838,000.00	50,038,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(44,961,333.53)	(42,704,666.93)
39205	Машин тоног төхөөрөмж, (компьютер)	1,065,639,313.01	1,114,970,713.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(760,458,347.61)	(814,576,095.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,560,742.40	49,560,742.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,623,658.66)	(41,666,639.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	120,000.00	120,000.00
393	Биет бус хөрөнгө	29,217,622.26	27,229,288.98
39301	Програм хангамж	7,010,000.00	7,010,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,472,777.74)	(5,461,111.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,680,400.00	25,680,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,214,566,774.43	1,113,259,538.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	824,231.00	3,357,225.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	824,231.00	3,357,225.00
413	Өглөг	824,231.00	3,357,225.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	218,631.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	326,000.00	-
4136	Бусад өглөг	279,600.00	3,357,225.00
41361	Байгууллагад төлөх өглөг	279,600.00	3,357,225.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,213,742,543.43	1,109,902,313.03
51	Засгийн газрын хувь оролцоо	1,213,742,543.43	1,109,902,313.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,233,840,996.88	1,233,840,996.88
51101	Өмч: - төрийн	1,233,840,996.88	1,233,840,996.88
512	Хуримтлагдсан үр дүн	(441,378,910.75)	(545,219,141.15)
51210	Өмнөх үеийн үр дүн	(477,353,622.39)	(441,378,910.75)
51220	Тайлант үеийн үр дүн	35,974,711.65	(103,840,230.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	421,280,457.30	421,280,457.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,214,566,774.43	1,113,259,538.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,026,449,253.00	959,434,238.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	252,778,733.00	254,373,538.00
120	Нийтлэг татварын бус орлого	252,778,733.00	254,373,538.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	252,778,733.00	254,373,538.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	227,539,519.00	239,108,038.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,239,214.00	15,265,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	773,670,520.00	705,060,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	752,846,300.00	705,060,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	752,846,300.00	705,060,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,824,220.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,824,220.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	938,493,576.00	990,134,468.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	938,493,576.00	990,134,468.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	832,157,255.35	875,290,319.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,107,094.00	454,226,659.62
210101	Үндсэн цалин	235,199,389.00	268,538,259.62
210102	Нэмэгдэл	147,135,705.00	141,542,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,772,000.00	36,146,000.00
210104	Урамшуулал	-	8,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,935,727.82	61,439,300.00
210201	Тэтгэврийн даатгал	40,362,141.83	44,576,413.02
210202	Тэтгэмжийн даатгал	4,230,917.83	4,150,535.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,147,232.12	3,414,612.38
210204	Ажилгүйдлийн даатгал	835,621.44	845,267.17
210205	Эрүүл мэндийн даатгал	8,359,814.60	8,452,471.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,811,100.00	27,797,900.00
210301	Гэрэл, цахилгаан	15,423,929.80	15,427,600.00
210302	Түлш, халаалт	11,387,170.20	12,150,300.00
210303	Цэвэр, бохир ус	-	220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,633,425.50	26,017,020.06
210401	Бичиг хэрэг	10,168,439.26	7,256,173.28
210402	Тээвэр, шатахуун	9,650,000.00	13,097,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,594.54	1,546,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	-	1,005,867.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	33,389,974.70	-
210408	Бараа материал акталсны зардал	1,431,417.00	3,111,179.78
2105	Нормативт зардал	1,197,769.26	21,420,055.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,197,769.26	21,420,055.57
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,741,555.00	22,937,895.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,212,400.00	13,141,618.00
210604	Урсгал засвар	17,529,155.00	9,796,277.00
2107	Томилолт, зочны зардал	3,793,066.00	8,797,245.00
210702	Дотоод албан томилолт	3,793,066.00	8,797,245.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,974,847.01	59,115,275.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,961,315.01	48,582,436.72

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,445,500.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	136,620.00	276,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,532.00	133,276.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,047,800.00	5,320,000.00
210807	Газрын төлбөр	231,080.00	126,353.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	201,962,670.77	193,538,968.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,349,853.26	87,347,962.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,848,000.00	2,492,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,764,817.51	103,699,006.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,336,320.65	114,844,148.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,771,761.01	63,164,181.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,652,776.01	53,454,181.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,118,985.00	9,710,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	69,564,559.64	51,679,967.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,564,559.64	51,679,967.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	87,955,677.00	(30,700,230.40)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	51,980,965.35	73,140,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	51,980,965.35	73,140,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(51,980,965.35)	(73,140,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	35,974,711.65	103,840,230.40

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,233,840,996.88	451,141,816.06	(507,214,981.5)	1,177,767, 831.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			29,861,358.76	29,861,358.76
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,233,840,996.88	451,141,816.06	(477,353,622.39)	1,207,629,190.55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		(29,861,358.76)		(29,861,358.76)
Тайлант үеийн үр дүн			35,974,711.65	35,974,711.65
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,233,840,996.88	421,280,457.30	(441,378,910.75)	1,213,742,543.43
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,233,840,996.88	421,280,457.30	(441,378,910.75)	1,213,742,543.43
Тайлант үеийн үр дүн			(103,840,230.40)	(103,840,230.40)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,233,840,996.88	421,280,457.30	(545,219,141.15)	1,109,902,313.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,049,744,757.26</u>	<u>966,503,112.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	192,073,469.00	261,442,412.00
120	Нийтлэг татварын бус орлого	192,073,469.00	261,442,412.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	192,073,469.00	261,442,412.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	192,073,469.00	261,442,412.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,671,288.26	705,060,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	752,846,300.00	705,060,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	752,846,300.00	705,060,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,824,988.26	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	84,000,768.26	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,824,220.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>919,206,457.26</u>	<u>917,171,712.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	919,206,457.26	917,171,712.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	811,294,221.61	803,903,478.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,217,586.34	454,418,236.43
210101	Үндсэн цалин	235,309,881.34	268,729,836.43
210102	Нэмэгдэл	147,135,705.00	141,542,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,772,000.00	36,146,000.00
210104	Урамшуулал	-	8,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,935,727.82	61,349,300.00
210201	Тэтгэврийн даатгал	40,362,141.83	43,171,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,230,917.83	4,544,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,147,232.12	3,635,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	835,621.44	908,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,359,814.60	9,088,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,657,600.00	27,797,900.00
210301	Гэрэл, цахилгаан	9,147,200.00	15,427,600.00
210302	Түлш, халаалт	12,530,400.00	12,150,300.00
210303	Цэвэр, бохир ус	1,980,000.00	220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,974,924.54	23,002,680.00
210401	Бичиг хэрэг	5,810,300.00	8,756,280.00
210402	Тээвэр, шатахуун	12,171,030.00	11,700,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,594.54	1,546,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000,000.00
2105	Нормативт зардал	6,141,200.00	21,212,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,141,200.00	21,212,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,782,391.50	19,966,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,300,000.00	240,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,894,750.00	9,930,000.00

210604	Урсгал засвар	20,587,641.50	9,796,450.00
2107	Томилолт, зочны зардал	3,802,036.00	8,797,245.00
210702	Дотоод албан томилолт	3,802,036.00	8,797,245.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,159,817.01	78,868,923.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,955 285.01	60,836 084.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,636,500.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	136,620.00	276,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,532.00	133,276.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,047,800.00	12,820,000.00
210807	Газрын төлбөр	231,080.00	126,353.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,622,938.40	108,490,344.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,444,938.40	105,998,344.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,178,000.00	2,492,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,912,235.65	113,268,233.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,347,676.01	61,588,266.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,652,776.01	53,454,181.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,694,900.00	8,134,085.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	69,564,559.64	51,679,967.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,564,559.64	51,679,967.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>130,538,300.00</u>	<u>49,331,400.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	130,538,300.00	49,331,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	130,538,300.00	49,331,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	130,538,300.00	49,331,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	130,538,300.00	49,331,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(130,538,300.00)</u>	<u>(49,331,400.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	915,339,500.00	914,823,144.43	516,355.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	915,339,500.00	914,823,144.43	516,355.57
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	853,700,900.00	853,234,878.43	466,021.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,539,300.00	454,418,236.43	121,063.57
210101	Үндсэн цалин	276,850,900.00	268,729,836.43	8,121,063.57
210102	Нэмэгдэл	141,542,400.00	141,542,400.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,146,000.00	36,146,000.00	
210104	Урамшуулал		8,000,000.00	(8,000,000.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,349,300.00	61,349,300.00	
210201	Тэтгэврийн даатгал	43,171,700.00	43,171,700.00	
210202	Тэтгэмжийн даатгал	4,544,400.00	4,544,400.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,635,500.00	3,635,500.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	908,900.00	908,900.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	9,088,800.00	9,088,800.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,907,900.00	27,797,900.00	110,000.00
210301	Гэрэл цахилгаан	15,427,600.00	15,427,600.00	
210302	Түлш халаалт	12,150,300.00	12,150,300.00	
210303	Цэвэр бохир ус	330,000.00	220,000.00	110,000.00
2104	Хангамж бараа материалын зардал	23,006,100.00	23,002,680.00	3 420.00
210401	Бичиг хэрэг	8,756,800.00	8,756,280.00	520.00
210402	Тээвэр шатахуун	11,703,300.00	11,700,400.00	2 900.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,546,000.00	1,546,000.00	
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00	
2105	Нормативт зардал	21,212,400.00	21,212,400.00	
210501	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	21,212,400.00	21,212,400.00	
2106	Эд хогшил урсгал засварын зардал	38,605,000.00	38,59, 850.00	7,150.00
210601	Багаж техник хэрэгсэл	18,875,000.00	18,871,400.00	3,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,930,000.00	9,930,000.00	
210604	Урсгал засвар	9,800,000.00	9,796,450.00	3,550.00
2107	Томилолт зочны зардал	8,797,300.00	8,797,245.00	55.00
210702	Дотоод албан томилолт	8,797,300.00	8,797,245.00	55.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,779,900.00	109,568,923.00	210,977.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,537,600.00	91,536,084.00	1,516.00
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	4,600,000.00	4,600,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	565,000.00	276,210.00	288,790.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	139,000.00	133,276.00	5,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	12,734,900.00	12,820,000.00	(85,100.00)
210807	Газрын төлбөр	126,400.00	126,353.00	47.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,503,700.00	108,490,344.00	13,356.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,011,700.00	105,998,344.00	13,356.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,492,000.00	2,492,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,638,600.00	61,588,266.00	50,334.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,500,000.00	53,454,181.00	45,819.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	8,138,600.00	8,134,085.00	4,515.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	915,339,500.00	914,823,144.43	516,355.57
12000	Нийтлэг татварын бус орлого	210,278,800.00	261,442,412.00	(51,163,612.00)
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
12200	Тусламжийн орлого	705,060,700.00	653,380,732.43	51,679,967.57
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
610001	Төсвийн байгууллага	1	1	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32	
620001	Удирдах ажилтан	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23	
620003	Үйлчлэх ажилтан	8	8	
620004	Гэрээт ажилтан			

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад тайлант оны төсвөөс бараа материал нөөцлөхгүй байх, бараа материалын бүртгэлийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Наранчимэг, захирал Б.Жаргалсайхан нар хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь Монгол орны нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал сүргийг эрүүлжүүлэх, нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах, малын эм, биобэлдмэлийн чанарын сорилт баталгаажуулалтыг үндэсний болон олон улсын шаардлагад нийцүүлж чанартай гүйцэтгэх, баталгаат биобэлдмэлийг хэрэглэгчдэд нийлүүлэх, эмийн зохистой хэрэгцээг төлөвшүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллах зорилготой байна.

Монгол улсад үйлдвэрлэгдэж, импортлогдож шинээр зохион бүтээгдэж буй мал амьтны гоц халдварт болон паразит буюу халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, оношлох эм био бэлдмэл, эмийн түүхий эдэд хими, биологи, вирусологи, бактериологи, паразитологийн сорилт шинжилгээ хийх, сорилтын дүн гаргах баталгаажуулалтын дүгнэлт гаргах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан бөгөөд тайлант хугацаанд дотоод аудитын хяналт шалгалт хийгдээгүй тул дотоод аудиторос туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шалгагдагч байгууллага төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 938,493.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,384.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж материаллаг байдлын суурь үзүүлэлт болох нийт зардал өмнөх оноос материаллаг өөрчлөлт ороогүй тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101,307.2 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	48,342.7	22,822.8	(25,519.9)
Урьдчилгаа		7,200.0	7,200.0
Бараа материал	239,849.1	284,369.4	44,520.3
Үндсэн хөрөнгө	926,374.9	798,867.3	(127,507.6)
Нийт хөрөнгө	1,214,566.7	1,113,259.5	(101,307.2)
Өр төлбөр	824.2	3,357.2	2,533.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,213,742.5	1,109,902.3	(103,840.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,214,566.7	1,113,259.5	(101,307.2)

Авлага дансны үлдэгдэл 22,822.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 25,519.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн төлбөрт үйлчилгээний авлагыг барагдуулсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 7,200.0 мянган төгрөгөөр өссөн нь Дата ланд технологи ХХК-д программын төлбөрийг урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 284,369.4 мянган төгрөг болж, 44,520.3 мянган төгрөгөөр өссөн нь Мал эмнэлгийн ерөнхий газраас 6,808.0 мянган төгрөгийн халдвар хамгааллын хэрэгсэл шилжиж ирснээс 4,458.2 мянган төгрөгийг зарцуулж, 2,479.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 39,690.0 мянган төгрөгийн мал, мал амьтадын тэжээл бэлтгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 798,867.3 мянган төгрөг болж, 127,507.6 мянган төгрөгөөр буурсан нь 49,331.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг төсвийн хөрөнгөөр бэлтгэж, ТӨБЗГ-ын 2021 оны 01/596 тоот шийдвэрээр Мал эмнэлгийн ерөнхий газарт 83,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлж, тайлант онд 103,699.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны 3,357.2 мянган төгрөг болж, 2,533.0 мянган төгрөгөөр өссөн нь гэрлэн хаягийн төлбөрийн үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,109,902.3 мянган төгрөг болж, 103,840.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 67,015.0 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагч нэмэлт санхүүжилт олгоогүйгээс 20,824.2 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 9,974.2 мянга, 2021 оны ЗГ-ын 43 дугаар тогтоолын дагуу улсын төсвийн санхүүжилтийг багасгаж баталснаас 47,785.6 мянган төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалжээ

Нийт зардал өмнөх оноос 51,640.8 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан нь цар тахлын улмаас ажилчдын цалинг бууруулан олгож, цалин хөлс, нийгмийн даатгалын зардлыг хэмнэж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 709,893.4 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 140,000.0 мянга, нийт 849,893.4 мянган төгрөгийг зарцуулахаар төсвийн төслийг төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 849,893.4 мянган төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

Тайлант онд төсвийн тодотголоор тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 53,500.0 мянга, үхрийн арьс товруутах өвчний шинжилгээ судалгаанд 12,146.1 мянган төгрөгийг тус тус нэмж, 915,339.5 мянган төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 705,060.7 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 210,278.8 мянга, нийт 915,339.5 мянган төгрөг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 705,060.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлого 261,442.4 мянга, нийт 966,503.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 914,823.1 мянган төгрөгийг зарцуулж, 51,680.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 914,823.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний 516.4 мянган төгрөгийг хэмнэж ажилласантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	915,339.5	914,823.1	516.4	99.9
1.1	82504	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	78,757.3	78,757.3	00.0	100.0
1.2	82548	Мал амьтан эрүүлжүүлэх	39,760.0	39,760.0	00.0	100.0
1.3	70805	Хөдөө аж ахуй газар тариалан аж үйлдвэрийн бодлого, удирдлага	735,183.6	734,717.6	466.0	99.9
1.4	80802	Урсгал шилжүүлэг	61,638.6	61,588.2	50.4	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь үндсэн 32 ажилтантай, захиргаа аж ахуй, баталгаажуулалтын алба, бактерлогийн, эмийн болон химийн, омгийн, онош вирусийн гэсэн 6 гэсэн албанаас бүрддэг.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.9 хувьтай байна.

3.8 Аудитын гол асуудал

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд материаллаг дүнтэй буруу илэрхийлэл байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өмнөх аудитаар хүргүүлснийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд байршуулбал зохих 182 мэдээллээс 180 мэдээллийг байршуулж, үнийн дүн, тоон үзүүлэлтгүй 2 мэдээллийг байршуулахдаа хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж байх талаар албан шаардлага хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 40,099.3 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илрүүлснээс 17,033.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулах, 3,265.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлагын санал хүргүүлж, 19,800.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 40,099.3 мянган төгрөгийн бүртгэлийн алдааг залруулсан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 807.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагын биелэлт 100 хувь, 5,404.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 67 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	807.1	3	807.1	-	-	-
Зөвлөмж	3	5,404.1	2	2,891.8	1	2,512.3	33.3
Нийт дүн	6	6,211.2	5	3,698.9	1	2,512.3	16.6

Төсвийг зөв зохистой удирдаж авлага, өглөг үүсгэхгүй байх 2,512.3 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52,534.6 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 16,900.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,841.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 26,422.6 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7,369.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 35,634.0 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 9,384.9 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалыг буруу ангилж бүртгэсэн 16,260.0 мянган төгрөгийн хөрөнгө;
- Эдийн засгийн ангилал буруу бүртгэсэн 640.6 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Төлбөрийн акт

Захирлын тушаалаар байгууллагын бүтэц, чиг үүрэг, орон тоонд батлагдаагүй албан ажлыг хавсран гүйцэтгэснээр тооцож, 1,841.9 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдаагүй орон тоонд ажиллуулж хавсран ажилласны нэмэгдэл олгосон зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Албан шаардлага

Тайлант оны 3 дугаар сард өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд дараа сард нь Хөдөлмөрийн дотоод журмын 7.3.12-т "Ажилтан хүндээр өвчилсөн үед 1-3 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг 1 удаа олгож болно" гэсэн заалтыг үндэслэсэн тушаалын дагуу 3,265.4 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Тайлант онд төсвийг зөв, зохистой удирдаагүйгээс 3,357.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.5 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Малын эмийн сорилтонд хэрэглэх 112 толгой малыг харилцан хамаарал бүхий 2 компаниас үнийн санал авч, худалдан авалтанд хамааралгүй үйл ажиллагааны чиглэлтэй аж ахуй нэгжтэй мал худалдах, худалдан авах гэрээг байгуулж сорилтонд ашиглах малд тавьсан амьдын жингийн шалгуурыг шалгаж жинлэж бүртгэлгүйгээр 19,800.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “Төсвийн захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын болон үндсэн хөрөнгийн бүртгэл нь Нягтлан бодох бүртгэлийн програмаас гарч буй мэдээ тайланд тусгагдахдаа давхардсан журналын бичилттэй боловсруулагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “Нягтлан бодох хөтлөх тухай” 14 дүгээр зүйлийн 14.3.3-т “Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 14.3.4-д “Ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5-д “Санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэн ажиллах, санхүүгийн программ хангамжаас бараа материал болон үндсэн хөрөнгийн мэдээллийн давхардлыг арилгаж, сайжруулалтыг хийх.

2. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст 2,479.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч, бодит хэрэгцээнээс илүү нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж, бараа материалын нөөц үүсгэхгүй байх.

3. Илрүүлэлт:

Бараа материалын ангилал зөрчиж бичиг хэргийн материалд 720.0 мянган төгрөгийн аж ахуйн материал бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажиллаж, бараа материалыг үнэн зөв ангилж бүртгэх.

2.Тайлан оны зардалтай холбоотой асуудал

4.Илрүүлэлт:

Тайлант онд 4,170.0 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцас ашиглалтанд олгосныг ашиглалтын хугацааг харгалзахгүй зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг хэрэгжүүлэн ажиллаж, хөдөлмөр хамгааллын хувцасны ашиглагдах хугацааг тооцож зардлаар хүлээн зөвшөөрч байх.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Бараа материалыг буруу ангилж бүртгэсэн	Бараа материалыг зөв ангилж бүртгэж байх	1	16,260.0	1	16,260.0									
2	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Эдийн засгийн ангилал буруу бүртгэсэн	Эдийн засгийн ангилал зөв бүртгэж байх	1	640.6	1	640.6									
3	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл нь санхүүгийн программаар алдаатай боловсруудагдаж байна.	Санхүүгийн программ хангамжийг сайжруулах												1	
4	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Хөдөлмөр хамгааллын хувцас ашиглалтанд олгосныг ашиглалтын хугацааг харгалзахгүй зардлаар тайлагнасан	Хөдөлмөр хамгааллын хувцасны ашиглалтын норм тогтоож ажиллах	1	4,170.0										1	4,170.0

5	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Бичиг хэргийн материал худалдан авч, бодит хэрэгцээнээс илүү нөөцөлсөн	Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах	1	2,479.5								1	2,479.5
6	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Бараа материалын ангилал зөрчиж бичиг хэргийн материалд аж ахуйн материал бүртгэсэн	Бараа материалын ангиллыг зөв бүртгэж байх	1	720.0								1	720.0
7	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Тайлант оны 3 дугаар сард өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд дараа сард нь тэтгэмж олгосон	Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах	1	3,265.4				1	3,265.4				
8	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Тайлант онд төсвийг зөв, зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн нь	Өр төлбөр үүсгэхгүй ажиллах	1	3,357.2				1	3,357.2				
9	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Малын эмийн сорилтонд хэрэглэх 112 толгой малын худалдан авалтын хийхдээ зохих шалгуур үзүүлэлтийг хангаагүй, анхан шатны баримт зөрүүтэй байна.	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу явуулах, бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг үнэн зөв дүгнэж байх	1	19,800.0				1	19,800.0				
10	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Байгууллагын бүтэц, чиг үүрэг, орон тоонд батлагдаагүй албан ажлыг хавсран гүйцэтгэснээр тооцож	Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах	1	1,841.9			1	1,841.9					
ДҮН					10	52,534.6	2	16,900.6	1	1,841.9	3	26,422.6		4	7,369.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал															
1	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд үнийн дүн, тоон үүлэлтгүй мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	2	Шилэн дасны хуулийг хэрэгжүүлж хуулийн хугацаанд мэдээлж байх	1						1			
	ДҮН											1			
	НИЙТ ДҮН				11	52,534.6	2	16,900.6	1	1,841.9	4	26,422.6		4	7,369.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 210/А0150458
АХГ-2022/346/МА-СТА-ПМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 3 дугаар сард өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд Хөдөлмөрийн дотоод журмын 7.3.12 "Ажилтан хүндээр өвчилсөн үе 1-3 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг 1 удаа олгож болно" гэсэн заалтыг үндэслэн 4 дүгээр сард 3,265,400.00 төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын Захирал А.Оргил, нягтлан бодогч У.Баатаржав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

C. G.

B. K.

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР *А. Мөнхцэцэг* А.МӨНХЦЭЦЭГ

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-216.Docx

0010800632



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 214/20150458
АХГ-2022/346/НА-СТЯ-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1 заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийг зөв, зохистой удирдаагүйгээс 3,357,225.00 төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зөв зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын Захирал А.Оргил, нягтлан бодогч У.Баатаржав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

9006109
9010130396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 211/АД/50458

Улаанбаатар хот

АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1 заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын эмийн сорилтод хэрэглэх 112 толгой малыг харилцан хамаарал бүхий 2 компаниас үнийн санал авч, худалдан авалтад хамааралгүй үйл ажиллагааны чиглэлтэй аж ахуй нэгжтэй мал худалдах, худалдан авах гэрээг байгуулж, сорилтод ашиглах малд тавьсан амьдын жингийн шалгуурыг шалгаж жинлэж бүртгэлгүйгээр 19,800,000.00 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "Төсвийн захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1."Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах,
2. Худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, энэ талаар байгууллагын дотоод дүрэм, журамд хариуцлага, хяналтын заалтуудыг нэмж тусган, гүйцэтгэлийг хангуулах,
3. Зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
4. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын Захирал А.Оргил, нягтлан бодогч У.Баатаржав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

90061001\10.10.10.20\Bichig_Thereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-217.Docx
9019120396

0010800695



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 213/20150458
АХГ-2020/346/НА-СТА-ТМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1 заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт байршуулбал зохих 182 мэдээллээс үнийн дүн, тоон үзүүлэлтгүй 2 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3 “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын Захирал А.Оргил, нягтлан бодогч У.Баатаржав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 33/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/346/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1 заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирлын тушаалаар байгууллагын бүтэц, чиг үүрэг, орон тоонд батлаагүй албан ажлыг хавсран гүйцэтгэснээр тооцож 1,841,900.00 төгрөгийн цалинг нэр бүхий ажилтанд илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын нэр бүхий ажилтанд илүү олгосон 1,841,900.00 /Нэг сая найман зуун дөчин нэгэн мянга есөн зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь аудитын шалгалтын орлого 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын захирал А.Оргил, нягтлан бодогч У.Баатаржав нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тоируу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Gazar-35.Docx

001090126